



ХЭНТИЙ АЙМГИЙН
ЦЭНХЭРМАНДАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 04 сарын 09 өдөр

Дугаар 5/11

Модот

П.Баярсайханыг өндөр насны
тэтгэвэрт гаргах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дүгээр зүйлийн 66.1 дахь заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.1.1, 79 дүгээр зүйлийн 79.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус сумын Ойн ангийн дарга Пүрэвдоржийн Баярсайхан нь өндөр насны тэтгэвэр тогтоолгох насанд хүрсэн тул өөрийнх нь гаргасан хүсэлтийн дагуу 2026 оны 04 дүгээр сарын 09-ний өдрөөс эхлэн үүрэгт ажлаас нь чөлөөлсүгэй.

2.Ажлаас чөлөөлөгдсөн П.Баярсайханы ажил хүлээлцэх, бусад холбогдох тооцоог хийж дуусгахыг Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн (О.Батбаяр), Нярав (С.Ган-Очир)-т нарт тус тус үүрэг болгосугай.

3.Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Б.Ганзориг)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.МӨНХ-ОРГИЛ

